


- 1 Дараах онцлог шинж нь ямар төлөв байдлыг илэрхийлэх вэ?
Савныхаа хэлбэр дүрсийг дагадаггүй
Жижиг хэсэг нь эмх замбараатай
Шахагдахгүй


- A хатуу
- B шингэн
- C хий
- D плазма

- 2 Доорх зурагт жижиг хэсгийн онолоор төлөвийн ямар өөрчлөлтийг зөв дүрсэлсэн байна вэ?



- A хайлах
- B уурших
- C конденсацлах
- D хөлдөх

- 3 Дараах хийнүүдийг гурван өөр саванд хийж ижил температурт байлгав. Аль саванд хийн даралт хамгийн их байх вэ?




- A 1
- B 2
- C 3
- D бүгд адилхан

- 4 Хоолны давсны 200 грамм ханасан уусмалыг халааж ууршуулахад 50 грамм хатуу үлдэгдэл үүссэн байна. Уусмалд хэдэн грамм ус агуулагдаж байсан бэ?

- A 50
- B 150
- C 200
- D 250

5 Нэгэн хатуу бодисыг халаах үеийн төлөвийн шилжилтийг температур, хугацаанаас хамаарсан графикийг харуулав. Аль хэсэгт зөвхөн хий төлөвт байх боломжтой вэ?



- A A
- B B
- C C
- D D

6 Атомын дэс дугаар нь 11 байдаг элементийг сонгоно уу.

- A Ne
- B Na
- C Mg
- D Al

7 Дөрвөн өөр төрлийн материалын нягтыг хүснэгтэд харуулав. Ижил эзлэхүүнтэй савтай усанд дөрвөн материалыг хийв. Аль материал нь усны хамгийн гүнд живэх вэ? Усны нягт 1.0 г*см^{-3} байдаг.

	Материал	Нягт
A	Материал 1	0.1 г*см^{-3}
B	Материал 2	0.5 г*см^{-3}
C	Материал 3	1 г*см^{-3}
D	Материал 4	1.5 г*см^{-3}

- A A
- B B
- C C
- D D

8 Зургийг ажиглаад төгсгөлд нь химийн элемент, нэгдэл, холимгийн аль нь үүссэн болохыг тодорхойлоорой.



- A элемент
- B холимог
- C нэгдэл, холимог
- D нэгдэл

9 Дараах өгөгдлөөс нэгдлийг сонгоно уу?

- A саахарын уусмал
- B натри
- C натрийн хлорид
- D давсны уусмал

10 Судлаач нэгэн шинэ элемент /бодис/ нээжээ. Тэр нь гэрэлд гялтганадаг, шар өнгөтэй, цахилгаан дулаан сайн дамжуулдаг, өнгө нь хялбар хувирдаггүй байсан бол дараах элементүүдийн аль нь байж болох вэ?

- A хүхэр
- B зэс
- C алт
- D зэв

11 Дараах холимгуудаас алийг нь нэрэх аргаар ялгаж болох вэ?

- A ус ба давс
- B ус ба шороо
- C ус ба модны үртэс
- D ус ба спирт

12 Физикийн үзэгдлийг сонгоно уу

- A мод шатах
- B төмөр зэврэх
- C мөс хайлах
- D сүү гашлах

13 Кали дээр ус нэмжээ. Химийн урвалын үгэн тэгшитгэлийг сонгоно уу.

- A кали + ус → калийн ус
- B кали + ус → калийн гидроксид + устөрөгч
- C кали + ус → калийн гидроксид
- D кали + ус → калийн устөрөгч + гидроксид

14 Фенолфталеин индикатор нь ямар орчинд ягаан өнгөтэй болдог бэ?

- A $pH > 7$
- B $pH < 7$
- C $pH = 7$
- D аль нь ч биш


15 Калийн гидроксидын уусмал дээр метилоранжийн индикатороос хэдэн дуслыг дусааж илүүдэл орос цууны уусмал нэмжээ. Үүсэн уусмал ямар өнгөтэй болох вэ?

- A өнгөгүй
- B ягаан
- C шар
- D улаан

16 Төмрийг зэврэлээс хамгаалахын тулд аль аргыг хэрэглэж **болохгүй** вэ?

- A буцалсан усанд хийх
- B металлаар бүрэх
- C будах
- D лентээр ороох


17 Дараах зурагт будаг төмрийн зэврэлд хэрхэн нөлөөлөх талаар судалгааг харуулжээ. Хуруу шил P, Q дэх усны түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар аль мөрөнд зөв илэрхийлсэн бэ?



	Хуруу шил P	Хуруу шил Q
A	<u>буурна</u>	<u>еснө</u>
B	<u>өөрчлөгдөхгүй</u>	<u>еснө</u>
C	<u>еснө</u>	<u>буурна</u>
D	<u>еснө</u>	<u>өөрчлөгдөхгүй</u>

- A A
- B B
- C C
- D D

18 Доорх зурагт усны буцлах температур болон газар зүйн байршлыг харуулав. Хамгийн нам цэгийг сонгоорой.




- A Алтай хот
- B Улаанбаатар хот
- C Хөх нууруудын хотгор
- D Таван богд уулын Хүйтэн оргил

19 Аль нь хөрсийг бохирдуулж буй эх үүсвэр **БИШ** вэ?

- A үйлдвэрийн хаягдал усыг ил задгай асгах
- B хог хаягдал, бохир усаа ил задгай хаях
- C дулааны станц, уурын зуух, машинаас утаа гарах
- D намар модны навч шарлан газар унах

20 Сурагчид ургамлын өсөлтөд хүчиллэг бороо хэрхэн нөлөөлөхийг тодорхойлох туршилт төлөвлөх үед дараах таамаглалыг дэвшүүлжээ. Аль таамаглал илүү үндэслэлтэй байна вэ?



- A ангид хүчиллэг бороо орох боломжгүй
- B хүчиллэг бороог орлуулж хүчиллэг бодис бэлтгэх боломжтой
- C маш их цаг хугацаа шаардагдана
- D таамаглалаа ярилцаж нотолж болно.